

МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН УРАН ЗОХИОЛ ДАХЬ ХҮҮХДИЙН ТУУЖ СУДЛАЛЫН АСУУДАЛД

Э. Амарзаяа *

Түлхүүр үг: хүүхдийн утга зохиолын судлал, төрөл зүйл ангилал, монголын хүүхдийн тууж, хүүхдийн уран зохиол, тууж судлал

УДИРТГАЛ

Монголын хүүхдийн уран зохиол судлалд *хүүхдийн найраглал, хүүхдийн тууж, хүүхдийн роман, хүүхдийн жүжиг* зэрэг хүүхдэд зориулсан томоохон хэлбэрийн зохиолын төрөл зүйлийн үүсэл, хөгжил, хувьсал, ангилалыг дэлгэн судлах ажил 1990-иэд оноос хойш зогсонги байна. Хүүхдийн туужийн төрөл зүйлийг аваад үзэхэд бие даасан төрөл зүйл үүсээд (1952 оноос) 60 гаруй жил болсон. Монголын хүүхдийн уран зохиолын хүрээнд 150 орчим хүүхдийн тууж зохиогдон хэвлэгдэн гарсан. Хүүхдийн туужийн төрөл зүйлийг нарийвчлан судлах, үндсэн онцлогийг дэлгэн тодруулах, цааш дэлгэрүүлэх, ирээдүйн хөгжлийг нь тодорхойлох судалгаа явуулах нь тулгамдсан асуудал юм.

1. ЭХЭН ҮЕИЙН БАЙДАЛ

Монгол оронд орчин үеийн хүүхдийн утга зохиол үүсч, дэлгэрэн хөгжихөд нөлөөлсөн түүхэн үйл явдал бол туурга тусгаар улсаа байгуулах эрх чөлөөний хөдөлгөөнөөс улбаатай 1921 оны ардын хувьсгал билээ. Хориод оны эцсээр тэр үеийн сонин, мэдээнд орчин цагийн хүүхдийн уран зохиолын анхны бүтээлүүд хэвлэгдэн шүлэг, өгүүллэг, үлгэр өгүүллэг гэх мэтээр төрөл зүйлээр ялгарах хандлага гарч ирэв. Монголын орчин үеийн уран зохиолын анхны тууж бол Ц. Дамбадоржийн “Толбо нуур” (1924) юм. Уг туужийн онцлог нь түүхэн үйл явдлаас шууд тусган бичсэн бөгөөд зохиолд өрнөх үйл явдал иш баримттай, уншигчдад үнэмшил сайтай байх ёстой гэдэг зарчмыг баримталсан зохиол юм. “Толбо нуур” баримтат тууж бичигдсэн нь бусад зохиолч нарт шинэ цагийн туужийн төрлөөр бичих дадлага, туршлага боллоо. Үүний дараа С. Буяннэмэх “Малчин Товуудай” (1936), М. Ядамсүрэн “Гурван хүүхэн” (1936), “Залуу хос” (1937), Ц. Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” (1929) зэрэг тууж бичигдэв. Эдгээр нь утга агуулгын хувьд хүүхдийн уншлагад төдийлөн тохиромжгүй боловч монголын уран зохиолд хүүхдийн туужийн төрөл бүрэлдэн бий болох анхны хөрс суурь нь болов.

1930-1950 оны хооронд “хүүхдэд зориулсан тууж” бичигдээгүй учраас үүнийг орлуулах маягаар хувьсгал, түүхэн явдлын сэдэвтэй “Толбо нуур” (1924), “Гологдсон

* МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

хүүхэн” (1929), цэрэг эх орон, баатарлаг явдлын сэдэвтэй “Олзвой баатар” (1945), Ц. Уламбаяр “Энх тайвны манаа” (1951), “Аюуш” (1946) зэрэг туужийг хүүхдийн уншлагад өргөн хэрэглэж байв. Гэхдээ эдгээр бүтээл нь түүх, хувьсгалын тухай тоочин өгүүлсэн, хүүхдийн дотоод ертөнц, өсвөр үеийнхний амьдралын тухай бага харуулсан байдаг нь хүүхдийн уншлага гэхээсээ томчуудад хамаатай байлаа. Хүүхдийн дотоод ертөнц, тэдний амьдралын хэв маягийг харуулсан том хэлбэрийн зохиол илт дутагдаж байв. Ийм хэлбэрийн зохиол бичих нь тухайн үеийн зохиолчдод туурвих эрмэлзлэл, хүсэл сонирголоос гадна хүүхдийн зохиол урлалын туршлага шаардлагатай байв. Ерийн хүүхдийн өгүүллэгээс нэг шат ахисан хүүхдийн үргэлжилсэн үгийн томоохон зохиол бичих оролдлогыг зохиолч Д. Цэвэгмид эхлэн гаргасан юм. Түүний бичсэн “Хоньчин Найдан” (1935), “Бургаст голын Болд, Самбуу хоёр” (1936), “Сурагч Ганбат” (1945) зэрэг зохиол гарсан нь хүүхдийн уран зохиолд том дэвшил болжээ.

“Хоньчин Найдан” (1935) өгүүллэгт, арван хоёр настай Найдан хүү харгис эзэрхэг захирагч Сүрэнгийн хонь хариулна. Нэгэн өдөр Найдан хүү хонио бэлчээрээс туусаар явтал оройтож шөнийн харанхуй болжээ. Бяцхан хүү шөнийн түнэр харанхуй, элдэв чимээ анираас ихэд айж өөрийгөө зоригжуулан чангаар хашгиран хонио тууж ядан явтал чоно дайрч нэг ямааг нь идчихнэ. Шөнийн харанхуйд нэгэн морьтой хүн давхин ирэв. Найдан ааваа гэж угтан гүйтэл захирагч Сүрэн <<Юуны чинь аав>> гэж чангаар зандран шөнө болтол хонь хээр байлгав, чононд ямаа идүүлэв хэмээн уургаар занчин толгой түрүүгүй зоддог. Найдан гэртээ уйлж хариад учир явдлаа бүгдийг ээждээ хэлсэнд эх нь хүүгээ зоригтой хэмээн магтаад аавдаа энэ талаар битгий хэлээрэй. Аав чинь үүнээс болж хэрэг төвөгт орох вий хэмээн захиана. Найдангийн аав ээж хоёр захирагчийн үхэр мал, адуу хариулж хөл гарын үзүүрт нь зарагдаж амьдралаа зогоодог ядуу ард юм. Найдангийн аав Зоригт хүүгээ харгисаар зодуулсаныг мэдээд “...үнэн шударгаар хүчин зүтгэж яваа ядуу боолын үрийг шарх сорви болтол занчсан нь гомдолтой байна. Хойшид өсвөр нялх хүүхдийг зодохын оронд намайг зодож байвал зохистой юм биш үү...”¹ гэж хэлснээс захирагч Сүрэн аавыг нь улам үзэн ядах болжээ. Зоригт бол төрөлхөөс шулуун шударга, ухаан сэргэлэн, үг хурц билэг сайтай хүн бөгөөд захирагч Сүрэнгийн балмад дээрэнгүйг занг хурц мэргэн үгээр ихэд мохоодог байсан тул захирагч Сүрэн ихээхэн хорсож Зоригтыг биеэсээ холдуулах арга олж хугацаагүй цэргийн албанд явуулдаг. Хоньчин Найдан захирагчийн дарлалаас зугтаж чанга дуутай, цүзгэр их гэдэстэй ламд шавь орсон нь “*чонын амнаас гараад барын аманд оров*” гэгч болдог. Найдангийн ээж ядуу бэрх амьдрал, хүнд бэрх ажлаасаа ужиг өвчин олж улмаар нас бардаг. Захирагч Сүрэн өнчирсөн хүүт эзгүй бууцан дээр ганцаар үлдээн нүүн одно. Очих газаргүй, дэмжих тулах хүнгүй хэрхэхээ мэдэхгүй өнчин хүүт Молом хэмээх нутгийн өвгөн үрчилж аван өсгөнө. Цаг цагаараа байдаггүй цахилдаг хөхөөрөө байдаггүй тул цаг төр өөрчлөгдөж сайн цаг ирж бяцхан хүү Найдангийн амьдрал гэрэл гэгээтэй учирна. Олон жилийн дараа нэгэн үл таних настай хүн өөртэй нь уулзахаар сураглан явсан тухай баярт мэдээ Найданд дуулдсанаар өгүүллэг төгснө. Энэ өгүүллэг нь бүхэлдээ хувьсгалаас өмнөх үеийн балчир хүүхдийн амьдрал, өсвөр үеийнхний хонь хариулах, бусдын гарт зарцлагдах, харгис хэрцгий захирагч эздэд хэрхэн дарлагдаж буй тухай хурц тодоор харуулсан бүтээл болов.

¹Лхамсүрэн П. Юнгэрэн Д. (2008) Ухаан далай номоос эхтэй. 2 цуврал. УБ., 46 тал.

“Болд, Самбуу хоёр” өгүүллэгт ² хүүхэмсэг, эдийн шуналтай гавж Лувсандандар гэгчийн шавь болох бага настай Самбуу хүүгийн тухай өгүүлнэ. Самбуу хүүг эрдэм ном сургах нэрээр лам багш нь ус зөөх, аргал түлээ бэлдүүлэх, хог цэвэрлэх, хоол унд бэлтгүүлэх зэргээр өдөржин зарцлах, зэргэлдээ айлын гэвш залуу буг чөтгөр, сүнс шулам зэргээр айлгаж шөний турш доромжлон зовоох явдал гарна. Завшаан болж Самбуу хүү гэртээ түр харих боломж олдов. Хариад эх эцэг, охин дүү нартайгаа учралдан багаасаа үерхэн тоглож өссөн Болд охинтой уулзаж ихэд баяр хөөр төрөөд хийдийн зүг буцах сэтгэлээ орхино. Энэ үед Болд охины ах нь хот явж сургуульд орж улаан бүч зүүсэн шинэ цагийн сурагч болсон ба Самбуутай уулзаж сургуульд суралцах хэрэгтэй тухай ихэд ятган хот газар, шинэ цагийн сургуулийн тухай ухуулан учир байдлыг тайлбарлан ярьж өгнө. Самбуу өөрийн найз Болд түүний ах улаан бүчит сурагчтай цуг хот газар явж шинэ цагийн сургуульд ордог. Эдгээр зохиолууд нь ерийн хүүхдэд зориулсан өгүүллэгээс нэн том хэмжээтэй байсан тул зарим судлаачид “**бүрэн хэмжээний тууж**” мөн хэмээн үзэж судалгааны ном бүтээлдээ тэмдэглэгдсэн байдаг нь сонирхолтой. Тухайлбал Ш. Цэнд-Аюушийн “Монгол тууж” (1981) бүтээлд, “Д. Цэвэгмидийн <<Болд Самбуу хоёр>> (57-р тал) <<Хоньчин Найдан>> (54-р тал) зэрэг зохиолыг ЗХУ-ын эрдэмтэн Г. И. Михайлов номондоо (<<Очерки истории современной Монгольской литературы>> АН СССР, М. 1955) тууж гэж үзжээ.”³ хэмээсэн нь сонирхол татдаг.

Эрдэмтэн зохиолч Ш. Гаадамба “...Монголын шинэ уран зохиолд тууж нэлээд дэлгэрчээ. <<Гологдсон хүүхэн>> гэдэг зохиолд гол баатар Цэрэн хүүхний бага наснаас эхлээд албан ажил хийх болсон хүртэл хорь гаруй жилийн явдлыг бичсэн учир тууж болно. Хоньчин Найдан, Болд Самбуу хоёр, Аюуш гэх мэт зохиолууд нь уул гол баатруудын амьдралын нэг тодорхой үеийг багтаан дүрсэлсэн учир цөм тууж болно...”⁴ гэж үзжээ. Хүүхдийн зохиол судлаач Д. Өлзийбаяр “Хүүхдийн зохиолын шилдэг бүтээлийн нэг, ахмад зохиолч Д. Цэвэгмидийн <<Болд Самбуу хоёр>>, <<Сурагч Ганбат>> туужууд 60-аад оны дундуур тус тусдаа ном болон хэвлэгдсэн...”⁵ эрдэмтэн зохиолч Ч. Арьяасүрэн “...Хуучин ертөнцийн сургалтын бүдүүлэг хүрэнээс ангижран, шинэ соёлын гайхамшигтай учран золгож байгаа хүүхдийн амьдрал зохиолд дүрслэгдэх болов. Зохиолч Д. Цэвэгмид шарын шашны том толгой лам нарын яхир хатуу зан авир, мөхөж байгаа хуучин хүрээ хийдийн явцуу амьдралыг сургууль соёлын саруул замтай харьцуулсан <<Хоньчин Найдан>> (1935), <<Болд Самбуу хоёр>> (1936) туужууд бичиж хүүхдийн утга зохиолд шинэ мөр гаргав...”⁶ гэхчилэн 1930, 1940-өөд оны утга зохиолын талаар өгүүлсэн судалгааны зарим ном бүтээлд туужийн төрөлд оруулсан байдаг. Эдүгээ дийлэнх судлаачид санал нэгтэй эдгээр зохиолыг “**томоохон өгүүллэг**” хэмээн тооцсон.

Аливаа нэг зохиолын тухайд төрөл зүйлийн маргаан гарах, аль төрөлд хамаарахыг нь хөтөлбөргүй тогтоох зэрэг нь тухайн төрлийн хөгжлийг тодорхойлох, шинж төлөв, үндсэн бүтцийн онцлогийг тодруулах судалгааны талбар болдог ажээ. Энэ үүднээсээ 1940-өөд оны дунд үеэс зөвхөн хүүхдийн уншлагад зориулагдсан уран сайхны тууж байж болох тухай зарчмын асуудал хүүхдийн уран зохиолд тавигдаж эхэлсэн юм.

² Мөн номын 14 тал

³ Цэнд-Аюуш Ш. (1981) Монгол тууж. УБ., 13 тал /дам ишлэв/

⁴ Гаадамба Ш. (1989) Утга зохиолын онолын үндэс. УБ., 196 тал

⁵ Өлзийбаяр Д. (1979) Хүүхдийн зохиолын тухай бодол. УБ., 26 тал

⁶ Арьяасүрэн Ч. (1980) Орчин үеийн монголын хүүхдийн утга зохиол. (1921-1971) I дэвтэр УБ., 9 тал

Хэдийгээр зохиолч Д. Цэвэгмидийн бүтээлүүд судлаачдын дунд төрөл зүйлийн талаарх томоохон хэмжээний мэтгэлцээн үүсгэсэн ч гэсэн “хүүхдийн тууж”-д тавигдах шаардлагыг бүрэн хангаж чадсангүй. Уран сайхны өндөр шаардлага хангасан хүүхдийн бүрэн хэмжээний тууж бүтээе гэвэл ерөнхий агуулга, утга санааны хувьд ямар байвал зохилтой вэ? Дүр баатруудын хэв шинж, онцлог нь юу вэ? Хэлбэр хэмжээний хувьд хэдэн хуудсанд багтах вэ? Өгүүллэгээс юугаараа ялгаатай болох вэ? гэхчилэн онолын чухал асуултууд зохиолч нарын дунд тавигдаж байлаа. Хүүхдэд зориулагдсан шинэ хэлбэрийн тууж бүтээх нь зохиолчдоос зөвхөн уран бүтээлийн эрэл хайгуул хийх төдийгүй, “уран сайхны бичлэгийн зоримог туршилт” хийх ажиллагаа шаардаж байлаа.

2. АНХНЫ ТУУЖ МЭНДЭЛСЭН НЬ...

Монголын хүүхдэд зориулсан анхны тууж болох “Манай сургуулийнхан”-г ⁷ /1952/ бичих түүхэн завшаан нэрт зохиолч Ч. Лодойдамбад тохиожээ. Энэ туужийн өмнө Ч. Лодойдамба зохиолч уншигч хүүхдэд нэлээд сонирхолтой байж болох “Малгайтай чоно” /1945/ хэмээх өгүүллэг, “Алтайд” (1949) хэмээх адал явдлын бэсрэг роман бичсэн нь сонирхолтой зохиомж, үйл явдал бүхий том хэлбэрийн хүүхдийн зохиол бичих үндсийг тавьсан юм. Уг туужийг бичих санаа өөрт нь хэрхэн төрсөн тухай зохиолч тэмдэглэхдээ, “... Нэг өглөө танил эмч Сүхбаатартай уулзахад тэр “Саяхан чамтай дайралдсанаас хойш Булган аймагт дуудлагаар явж мэс засал хийгээд ирлээ” гэсэн юм. Үүнээс сэдэв олж багадаа суралцаж байсан танхимын сургуулийн амьдрал дээр тулгуурлан энэ туужийг бичсэн юм гэж хуучилсан байдаг...”⁸ Ч. Лодойдамба зохиолчийн бага насны амьдралд уг туужийн сэдэвтэй дам холбогдох бодит дурсамж бий ажээ. Тэрбээр хүүхэд байхдаа “Тандандэгчлин” хийдэд шавилан сууж шашны ном үзэж төвд үсэг цээжлэхийн зэрэгцээ багшийн цай хоол хийх, хог шороо цэвэрлэх, ус түлээ бэлдэх, ялихгүй зүйлээс болж багш ламаас харгис авир, зодуур шийтгэл хүлээх болжээ. Түүний дурсамжинд “Сүм хийдийн бурангуй орчинд гурван жилийг арай чамай өнгөрүүлсний дараа Лодойдамба хоёр нөхрийн хамт оргожээ. Тэр гуравт зам зуур хэрэглэх жаахан боорцог, хэдэн лаа, 15 төгрөг, хогноос олсон хугархай сэлэмнээс өөр юу ч байсангүй. Тэд өдөр нь нуугдан шөнө нь явсаар 150 км холдсоны дараа багш ламын гараас мултарлаа гэж итгэн өдөр явж байтал багш лам нь гүйцэн ирж баривчлан авчээ. Тэр гурвын гарыг ард нь хүлж, хялгасан аргамжаар хүзүүгээр нь оосорлон морин тэрэгний араас уяж шогшуулна. Зам зуур хоноглох газарт тэр гурвыг мөн л тэрэгний дугуйтай холбон уяна. Ингээж зургаан хоног явсаар хийдэд хүрч ирвэл дайралдсан лам бүр алганыхаа ар өврөөр хоёр хацрыг нь хавдтал алгадан шийтгээжээ... 1927 оны хаврын дулаан цэлмэг нэгэн шөнө Лодойдамба сүм хийдийг үүрд орхиж гэртээ ирэв...”⁹ хэмээсэн нь туужийн үүдэл санаа зохиолчийн амьдралын дурсамжтай холбоотой баримт юм.

Уг зохиолд 1927 оны үеийн бага сургуулийн сурагч хүүхдүүдийн амьдралын тухай нарийвчлан харуулсан. Зүрх уулын танхимын сурагчид болох бэтэг өвчтэй дорой биетэй Бурантаг, чадал тэнхээтэй боловч түүндээ эрддэгүй тусч Балдан, хөдөлгөөнтэй үймүүлэх дуртай Бат болон Чулуун, Эрдэнэ, Дорж, Сүрэн зэрэг бусад хүүхдийн дүр гардаг. Хүүхдүүд оньсого таалцан тоглох, мэдэхгүй зүйлийнхээ тухайд харилцан тааварлах, хүсэл мөрөөдлөө ярилцах зэргээр уг зохиолын хуудас бүрт хүүхдийн

⁷ Лхамсүрэн П. Юнгэрэн Д. (2008) Ухаан далай номоос эхтэй. 10 цуврал. УБ., 8 тал

⁸ Ганбат Б. (1998) Монголын сонгодог зохиолч Чадраабалын Лодойдамба. УБ., 124 тал

⁹ Дүгэрсүрэн Т. (1982) Чадраабалын Лодойдамба. УБ., 12 тал /дам ишлэв/

ертөнцийг илүүтэй харуулсан. Нэгэн өдөр ууртай багш болох Ням гүнд шийтгүүлж өдрийн хоол идэх эрхээ хасуулсан зохиолын баатар өлсөхийн эрхээр ойрхон байх хүрээ орж хар бор ажил хийж хоол олж идэхээр шийдэж хамт явах хүүхэд хайвал гадаа цасан шуурга тавьж байсан тул хань олдсонгүй. Өдрийн хоолоо бусдад булаалгасан Бурантаг хамт явахаар болов. Тэр хоёр нэг нэг унь бариад замд таарах золбин нохдыг хөөгөөд хүрээнд очтол арваад лам хүүхдүүд гарч ирж тэр хоёрыг дээрэлхэнэ. Олон банди нартай хэрхэн тэмцэх учраа олохгүй байтал Бурантаг эхлэн зориг гаргаж, улмаар хоёул нийлэн банди нарыг хөөж явуулаад нэгэн ламынд очиж гурван цаг мод хөрөөдөж хөлсөнд нь жижигхэн дугуй боов хоёрыг авсан билээ. Ингэж байтал танхимд халдварт өвчин дэлгэрч хүүхдүүд үүнд нэрвэгдэнэ. Нэг талаас хуучин үзэл суртал дүрэм журмыг баримтлагч Ням гүн, Лувсан оточ нар нөгөө талаас шинэ цагийн оюутны сургууль төгсч ирсэн Далхаанямбуу багш, орос эмч нарын хооронд гүнзгий зөрчил үүсч үүний талбар нь сурагч хүүхдүүд болно. Ням гүн, Лувсан оточ нарын харгайгаар тус Балдан, дүрсгүй Бат нарын зэрэг хүүхдүүд хүнд өвчин тусч амь насаа алдана. Далхаанямбуу багш, орос эмчийн тусламжтайгаар үлдсэн хүүхдүүдийн амийг аварна. Дундуурхан хоолтой, дутуухан нимгэн хувцастай, өлөн нойтон сурагч хүүхдүүд Далхаанямбуу багш болон сайхан сэтгэлтэй орос эмчийн ачаар сурч хүмүүжин зөв замдаа орж ирээдүйн эрдэмтэн Дорж, багш Эрдэнэ, жүжигчин Сүрэн, инженер Чулуун, эмч Дулмаа нар болцгоодог.

Уг туужтай харьцуулахад Д. Цэвэгмид болон бусад зохиолчдын өмнө гаргасан бүтээлүүд нь өгүүллэгийн хэмжээнд байсан бөгөөд дүр баатрууд, үйл явдал, хэлбэр хэмжээний хувьд туужийн шаардлагийг бүрэн хангасан анхны тууж бол “Манай сургуулийнхан” мөн хэмээн олон судлаач санал нэгтэй үзсэн юм. Энэ талаар “...Ч. Лодойдамбын хоёр дахь тууж <<Манай сургуулийнхан>> (1951) зөвхөн түүний уран бүтээлийн өсөлтийг харуулаад зогсоогүй, монголын уран зохиолын тууж бичлэгт гарсан тэмдэглэлт амжилт болсон юм... Зохиолч Ч. Лодойдамба үүнийг туужийнхаа гол сэдэв болгон авч оновчтой, тодорхой өгүүлэмж, цөөн баатруудын цэгцтэй үйл явдал, уран сайхны төгс боловсруулалтаар гаргахдаа эрт эдүгээ, хуучин шинэ хоёрыг зэрэгцүүлэн харьцуулах аргыг хэрэглэсэн нь зохиолын агуулгыг бүрэн гүйцэд гаргахад яг тохирсон хэлбэр болсон байна...”¹⁰ гэжээ. Урьд өмнөх хүүхдэд зориулсан зохиолуудын хүүхдийн дүр нь гол төлөв томчуудын дүрд хавчуулагдсан, голлох гэхээсээ туслах байдалтай, нилээн доройхон дүрслэгддэг байсан бол энэ туужийн гол цөм баатрууд нь хүүхдүүд өөрсдөө болсон төдийгүй өөрсдийн бодол хүсэл, сэтгэлийн дотоод ертөнцөө чөлөөтэй дэлгэн харуулах оролдлого гаргах болсоноороо монголын хүүхдийн уран зохиолд онцгой шинэчлэл болсон юм. Энэ зохиол нь утга зохиол судлаачдын дунд өндөр үнэлгээ авсан бөгөөд ер нь “Манай сургуулийнхан” туужийн талаар бичээгүй утга зохиол судлаач шүүмжлэгч ховор байдаг. Цаашлан судалбал “...Ардын соёл боловсролын хөгжлийн их замд тохиолдсон бэрхшээлийн дунд манай хүүхэд багачууд хатуужил тэсвэртэй суралцаж, үзэгдэл юмсын учир холбогдлыг аажим аажмаар танин мэдэж, зан төлөв нь хэлбэржин бүрэлдэж байгааг тууж нарийн өгүүлжээ. Ч. Лодойдамбын <<Манай сургуулийнхан>> тууж хүүхдийн ертөнцийг голчлон дүрсэлснээрээ хүүхдэд зориулсан том хэлбэрийн зохиолд чухал алхам болов. Тавиад оны хүүхдийн зохиолд баатрууд нь сургуулийн танхим, малын бэлчээр, тоглоомын талбайд өдөр тутам тааралдаж байдаг өнөөдрийн эгэл жирийн багачууд болж хувирсан юм...”

¹⁰ Лувсанвандан С. (1989) Монголын орчин үеийн уран зохиолын түүх (1941-1960) II боть. УБ., 273 тал.

¹¹ Гэх буюу “...Манай утга зохиолын нэгэн сүмбэр оргил <<Манай сургуулийнхан>> тууж 1952 онд хэвлэгдэн гарсан нь тавиад оны тууж бичлэгийн үнэхээр том ололт байлаа. Ч. Лодойдамбын энэ тууж нэгдүгээрт, шинэ хуучны зөрчлийн асуудлыг зөв тавьж шийдвэрлэснээрээ хоёрдугаарт, тууж зэрэг том зохиолын баатрын дүрийг гаргадаг намтарчлан тоочих, нэг хүнийг <<байнга дагах>> гадаад овор төрх байдлыг зураглан үзүүлэх зэрэг хэрэглэж дассан урьдын арга барилыг эвдэн өөрчилж, баатрын сэтгэхүй, түүний зөрчил, хувирал, төлөвшилтийг эрхэмлэн уран чадварлаг үзүүлснээрээ манай утга зохиолд чухам шинэ хандлага болж, тодорхой нөлөө үзүүлсэн юм...”¹² хэмээн дүгнэсэн жишээ татаж болно. Туужийн нэрийн тухай судалбал, “...Манай сургуулийнхан тууж анх “Хурим” гэсэн нэртэй байсныг сонирхуулъя. Зохиолчийн гар бичмэлийг үзвэл “Хурим” гэж анх гарчиглаад түүнийгээ сүүлд нь дугуйлан зурж “Манай сургуулийнхан” гэж өөрчилсөн байна. Мөн “Үнэн” сонины 1952 оны 112 дугаарт “Хурим гэдэг тууж хэлэлцсэн нь” гэсэн мэдээг Ж. Дүгэржав гэдэг хүн бичсэн байна. Тэнд “Монголын зохиолчдын эвлэлийн ерөнхий хорооны дэргэдэх үргэлжилсэн үгийн зохиолын секцийн гишүүд зохиолч нөхөр Ч. Лодойдамбын зохиосон “Хурим” гэдэг туужийг саяхан хэлэлцлээ” гээд туужид юу харуулсныг болон “...секцийн гишүүд уг туужийг хүлээн авахаар...”¹³ гэсэн түүхэн баримт бий.

Зохиолч Ч. Лодойдамба энэхүү туужаа бичсэнээс хоёр жил орчмын дараа БНМАУ-ын төрийн шагнал хүртсэн (“Алтайд” роман, “Манай сургуулийнхан” тууж бичсэний учир) байдаг нь уг тууж хэр зэрэг чансаатай бүтээл болсны илрэл юм. “Манай сургуулийнхан” туужийн туршлага бусад зохиолч нарт хүүхдийн туужийн төрөлд хүчээ үзэх их урам авчирсан юм. Ч. Лодойдамба 1960-иад онд Монголын орчин үеийн утга зохиолын ноён оргил болох “Тунгалаг Тамир” романыг туурвисан ба энэхүү цар хүрээ ихтэй монголын уран зохиолын сор болсон томоохон роман бичихэд нь “Манай сургуулийнхан” хүүхдийн тууж нь зохиолчийн урлал, бичлэгийн чадварт арвин туршлага болсон нь эргэлзээгүй юм. Энэ бүгдээс үзвэл монголын хүүхдийн анхны бүрэн хэмжээний туужийг “Манай сургуулийнхан” (1952) эргэлзээнгүй мөн гэж үзэх бүрэн үндэстэй, иш баримттай юм.

3. ХҮҮХДИЙН ТУУЖ НЬ ДЭЛГЭРСЭН НЬ

“Манай сургуулийнхан” тууж амжилттай болсноос хойш зохиолчид дунд хүүхдийн тууж бичих явдал 1950-1960 аад оны хооронд эрч хүчээ авлаа. Тодруулбал ойр ойрхон хугацаанд Л. Түдэв “Нөхөд” (1956), “Осолтой жим” (1957), П. Хорлоо “Говийн хүү” (1956) зэрэг тууж зэрэгцэн хэвлэгдэж хүүхдийн уншлагад оров. Хүүхдэд зориулсан бүтээл олноор гарах болсныг дагаад хүүхдийн уран зохиол судлал, шүүмжийн ажил эрчээ авав.

1960-1970 аад оны үед Л. Түдэв, П. Хорлоо, М. Чимид, Д. Гармаа, С. Надмид нарын олон зохиолч хүүхдэд зориулсан туужууд бичиж уран зөгнөлт, намтар тууж, адал явдлын гэх мэт олон жанр, чиглэл болон ихэд хөгжив. Тухайлбал, уран зөгнөлийн сэдвээр: Л. Түдэв “Будаг амилна” (1967), “Мөнхийн ус” (1969) Р. Ядмаа “Бараан хясаатын нууц” (1971) Адал явдалт сэдвээр: Д. Гармаа “Гавьяат үйлсийн мөрөөдөл” (1967), “Нэгэн зуны намтар” (1968), Ш. Гаадамба “Багын явдал” (1975), С. Надмид

¹¹ Арьяасүрэн Ч. (1980) Орчин үеийн монголын хүүхдийн утга зохиол (1921-1971) I дэвтэр УБ., 95 тал

¹² Цэнд-Аюуш Ш. (1981) Монгол тууж УБ., 26 тал

¹³ Ганбат Б. (1998) Монголын сонгодог зохиолч Чадраабалын Лодойдамба УБ., 141 тал

Дааганы уралдаан (1975), “Сүүдэрхүү” (1972) тэргүүтэй тууж хэвлэгджээ. Танин мэдэхүйн сэдвээр: Д. Мягмар “Балын амт” (1965), Л. Түдэв “Хорвоотой танилцсан түүх” (1970), Ч. Алагсай “Ирвэст уул” (1970) үүнээс гадна хувьсгалт тэмцэл, эрэлхэг баатарлаг явдал, намтарчилсан түүхэн сэдэв үргэлжлэн бичигдэж Л. Түдэв “Төөрөгсөд” (1963), Р. Ядмаа “Галд нэмэрлэсэн цучил” 1965, М. Чимид “Шар цамцат” (1965), Ч. Лувсанжав “Дамдины бага хүү” (1968), “Д. Сүхбаатар” (1970) зэрэг олон тууж гарав.

Л. Түдэвийн “Хорвоотой танилцсан түүх” туужид өгүүлэгч баатар болох бяцхан хүү чулуутай, дуутай, зурагтай, салхитай, цүнхтэй, хадны мангаа зэрэг өөрийг нь хүрээлэн буй юмс, үзэгдэлтэй хэрхэн танилцаж буй тухайгаа өгүүлнэ. “Нөхөд” (1956) туужийн талаар судлаач Д. Оюунбадрах ¹⁴ “...Нөхөд тууж өмнө нь салангид үйл явдал бүхий тус тус өгүүллэгүүдэд гарч байсан дүрүүдээ нэгтгэн нэгэн шугамын харилцан үйлчлэлд оруулан томоохон төрөл жанрыг буй болгосноороо шинэлэг юм...” хэмээн дүгнэсэн бол эрдэмтэн зохиолч Ч. Арьяасүрэн “...Тавиад онд хүүхдийг хөдөлмөр эрдмийг тэгш хослуулах зүгт уриалан дуудсан хандлага хүүхдийн зохиолд нэгэн чиглэл боллоо. Энэ хандлага манай орны сургуулиудаас сурагчдын зуны амралтыг үр ашигтай өнгөрүүлэх их ажил зохиож байсантай дагалдаж гарав. Тухайн сэдвийг Л. Түдэвийн “Нөхөд” тууж тодорхой үзүүлэв. Нэгэн салааны пионерүүд алтай нутгаар аялах замдаа янз бүрийн ургамал амьтан, хадны агуйтай дайралдаж хичээлээр олж авсан мэдлэгээ баяжуулж байна...” ¹⁵ гэхчилэн судалсан байдаг.

Гэхдээ энэ үеийн зарим тууж уран сайхны хувьд хүүхдийн уншлагад бүрэн тохирохоор утга төгөлдөр болоогүй, үүдэл санаагаа гүйцэд боловсруулаагүй, илэрхийлж буй утга санаа ядмаг, өрнөх үйл явдлыг агуулгандаа хүчээр захируулсан, хүүхдийн дотоод ертөнцийг бүрэн гаргаж чадаагүй, гол баатруудын дүр, үйл хөдлөл нь илт үнэмшил муутай болсон талууд ажиглагдаж байна. Тухайлбал М. Чимид “Шар цамцат” (1965) туужийн агуулга нь, Чулуунбаатар нэртэй “Шар цамцат” хочтой зургадугаар ангийн нилээн сахилгагүй, зодоонч сурагч жаал гэнэтхэн хүмүүжихээр шийдэж хөдөө атар газар очиж тракторчин болж улмаар бусдад үлгэр дууриалал болохуйц хөдөлмөрч нэгэн болсон тухай хоорондоо авцалдаагүй зүйлсийг хүчээр нийлүүлсэн зохиомжтой болжээ. Энэ мэтчилэн Ч. Бямбажавын “Хөдөөгийн тууж” (1972), З. Сандагийн “Банди” (1973), Т. Юмсүрэнгийн “Уулын голын шуугиан” (1974), Л. Соронзонболд “Цэрэг малгай” (), Ц. Эрдэнэбат “Журамт цэргийн хүү” (1971), Ч. Лувсанжав “Д. Сүхбаатар” (1970) зэрэг зохиомж утга санаа тааруухан, ерөнхий агуулга нь хүүхдийн зохиолд нийцэхгүй бүтээлүүд нэлээд элбэг бий.

Энэ бүгдээс үзвэл 1950-иад оноос эдүгээ хүртэлх хугацаанд монголын хүүхдэд зориулсан туужийн төрөл зүйл нь хөгжлийн шулуун дардан замаар явсан гэж үзэж болохгүй юм. Хүүхдэд төдий л хамааралгүй утга санаа бүхий нийтэд зориулсан бүтээлийг “хүүхдэд зориулсан тууж” гарцаагүй мөн хэмээн хүүхдийн уншлагад оруулах, ердийн томхон өгүүллэгийг “хүүхдийн тууж” хэмээн томруулж авч үзэх, эсвэл туужийн хэмжээний бүтээлийг “хүүхдийн роман” хэмээн өргөмжлөн нэрлэх үзэгдэл зохиолчид дунд эдүгээ хүртэл байсаар байгаа юм.

Үүний зэрэгцээ 1960 оноос хойш үргэлжилсэн үгийн хамгийн том хэлбэрийн зохиол болох романы төрөлд “хүүхдийн роман” бичих оролдлогууд нилээд гарсан. Тухайлбал Ө. Баасанжав “Алтан хараацай” (1966), “Мөнгөн хараацай” (1980), Р. Ядмаа “Дөрөөн

¹⁴ Оюунбадрах Д. (2009) Монголын хүүхдийн уран зохиол II боть. УБ., 52 тал.

¹⁵ Арьяасүрэн Ч. (1980) “Орчин үеийн монголын хүүхдийн утга зохиол” (1921-1971) I дэвтэр УБ., 96 тал.

дээр” (1974), С. Надмид “Нийслэлийн замд” (1986), М. Чимид “Сэтгэлийн нууц” (1987) Ш. Шажинбат “Говийн зүүд” (1986), З. Дорж “Сүүтэй чулуу” (1987), З. Сандагаа “Шальдар” бүлдэр нас (1982), Ш. Ванчаарай “Нарны сургууль” (1989) зэрэг нилээд роман гарсан боловч хүүхдэд зориулсан роман нь хүүхдийн туужийн төрлөө бодвол бүрэн хөгжиж, өсвөрийн уншигчийн дунд далайцтай нэр хүндийг олж чадаагүй юм. Үүний гол шалтгаан нь хүүхдийн романыг хүүхдийн сэтгэлийн дотоод ертөнцөөс холдуулсан, томчуудын амьдралын хүрээнээс гарч чадаагүй, ерөнхий агуулга, утга санаа, зохиолд гарах үйл явдлын хувьд хүүхдийн уншлагад тохироогүй, зохиомж, шийдэл зэргийг нь ямагт нүсэрдүүлж ирсэнд оршино.

Үргэлжилсэн үгийн томоохон төрөл зүйлээс гадна “хүүхдэд зориулсан өгүүллэг”, “хүүхдийн шүлэг”, “хүүхдийн найраглал”, “хүүхдийн жүжиг” зэрэг бусад төрөл зүйл ихэд хөгжиж энэ бүгдийн үр дүнд хүүхдийн утга зохиол нь 1960-аад оны үеэс нийтийн уран зохиолын нөмрөөс бүрэн гарч бие даасан салбар болон хөгжлөө. Энэ салбарын хөгжлийн үйл явцад бүхий л уран бүтээлээ хүүхдийн уран зохиолд зориулсан “хүүхдийн зохиолч”-дын хувь нэмэр үлэмж их юм.

ДҮГНЭЛТ

1. Ц. Дамбадорж “Толбо нуур” (1924), С. Буяннэмэх “Малчин Товуудай” (1936), М. Ядамсүрэн “Гурван хүүхэн” (1936), “Залуу хос” (1937), Ц. Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” (1929) зэрэг туужис утга агуулгын хувьд хүүхдийн уншлагад төдийлөн тохиромжгүй боловч хүүхдийн туужийн төрөл бүрэлдэн бий болоход анхдагч хөрс суурь, туршлага болсон.

2. Хүүхдийн үргэлжилсэн үгийн томоохон зохиол болох “тууж” бичих анхны оролдлогыг зохиолч Д. Цэвэгмид эхлэн гаргасан. Түүний бичсэн “Хоньчин Найдан” (1935), “Бургаст голын Болд, Самбуу хоёр” (1936), “Сурагч Ганбат” (1945) зэрэг зохиол нь ерийн хүүхдэд зориулсан өгүүллэгээс том хэмжээтэй байсан тул судлаачдын дунд “өгүүллэг” эсвэл “тууж” мөн хэмээн харилцан адилгүй үзэхэд хүргэж судалгааны ном бүтээлд зөрүүтэй тэмдэглэгдсэн байдаг нь сонирхолтой.

3. Монголын хүүхдийн уран зохиол дахь уран сайхны анхны тууж бол Ч. Лодойдамбын “Манай сургуулийнхан” (1952) тууж мөн бөгөөд ингэж үзэх нь онолын бүрэн үндэстэй, судалгааны иш баримттай юм. Уг туужийн гол дүрийн дийлэнх нь хүүхдүүд бөгөөд зохиомжийн төвд хүүхдийн ертөнцийг дүрсэлснээрээ хүүхдийн уран зохиолд томоохон алхам болжээ.

4. Хүүхдийн тууж нь хүүхдийн үргэлжилсэн үгийн зохиолын томоохон төрөл зүйл болон хөгжиж чадсан боловч хүүхдийн тууж судлал, төрөл зүйлийн ангилалын асуудал тулгамдсан хэвээр байна. Ийм болохоор хүүхдэд төдий л хамааралгүй утга санаа бүхий нийтэд зориулсан бүтээлийг “хүүхдэд зориулсан тууж” мөн хэмээн хүүхдийн уншлагад оруулах, ердийн томхон өгүүллэгийг “хүүхдийн тууж” гэж томруулж авч үзэх үзэгдэл эдүгээ хүртэл байсаар байгаа юм.

НОМЗҮЙ

1. Арьяасүрэн Ч. (1980) Орчин үеийн монголын хүүхдийн утга зохиол I дэвтэр. УБ.,
2. Гаадамба Ш. (1989) Утга зохиолын онолын үндэс. УБ.,
3. Ганбат Б. (1998) Монголын сонгодог зохиолч Чадраабалын Лодойдамба. УБ.,
4. Дүгэрсүрэн Т. (1982) Чадраабалын Лодойдамба намтар зохиол. УБ.,
5. Цэнд-Аюуш Ш. (1981) Монгол тууж. УБ.,
6. Лувсанвандан С. (1989) Монголын орчин үеийн уран зохиолын түүх II боть. УБ.,
7. Оюунбадрах Д. (2009) Монголын хүүхдийн уран зохиол II боть. УБ.,
8. Өлзийбаяр Д. (1979) Хүүхдийн зохиолын тухай бодол. УБ.,

SUMMARY

It has become major importance to define future evaluation, clarify feature, research classification as well as origin of “Children’s novel” style in Mongolian Children’s Literature. Tsevegmid.D made the first attempt to write Children’s novel such as “Khonchin Naidan”(1935), “Wicker river’s Bold and Sambuu” (1936), “Student Ganbat” (1945). However they were not same as novel, it was the first experience. It is reasonable and proven that “My schoolmates“(1952) by Lodoidamba.Ch is the first children’s novel. Children’s novel has been developed since 1952 and become one style of Children’s fiction.